

АУДИТИН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

ТЭЦ-2 утаагүй түлшний үйлдвэрийн төсвийн зарцуулалт, үр дүн

2. Аудитын код

/ҮАГ-НАГ /2014/06-НА/

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, ҮАГ-аас МУ-ын ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “ДЦС-2”-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгийг хэрхэн үр ашигтай зарцуулсан байдалд аудит хийж, дүнг УИХ-д танилцуулахад аудитын ажлын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.

Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр санхүүжсэн “210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах” төсөл үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
- Хагас коксжсон түлш үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлын энерготехнологийн төхөөрөмжийн найдвартай, тогтвортой ажиллагаа нь нүүрсний шинж чанараас хамааран хангагдахгүй байгаа талаарх дүгнэлт үндэслэлтэй эсэх.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитаар ЭХЯ, УУЯ болон тус төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Аморе интернэшнл” ХХК-ын 2010-2013 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хамруулна.

6. Үндсэн мэдээлэл

ЭБЭХЯ-наас 2010 онд зарласан ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн жилд 210 мянган тонн хагас кокжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгч сонгон шалгаруулалтад “Аморе интернэшнл” ХХК, ОХУ-ын “Сибтермо” ХХК-ын түншлэл шалгаран 2010

оны 7 дугаар сарын 9-нд 10/56 тоот гэрээг "Түлхүүр гардуулах нөхцөл"-өөр байгуулжээ.

Хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлын хүрээнд:

- ДЦС-2 ТӨХК-ний БКЗ-75-39ФБ маягийн 2 зуухыг "Энерго-технологийн төхөөрөмж" болгон өөрчлөх;
- Хагас коксжсон шахмал түлшний иж бүрэн үйлдвэр шинээр барих, турших;
- Хагас коксжсон шахмал түлшний агуулах барих;
- ДЦС-2 ТӨХК-ний түлш дамжуулах цехийн дамжлагыг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрс хүлээн авах талбайг томсгох, нүүрс бутлагчийг өөрчлөн солих зэрэг ажлууд орсон.

Техник технологийн шийдэл

- БКЗ-75-39ФБ маягийн завсарын бункертай, халуун агаараар тоос тээвэрлэх, үрлэн тээрэмтэй, тоос бэлтгэх системтэй 2 зуухыг энерго-технологийн төхөөрөмж болгон өөрчилж, эрчим хүчний технологийн уур үйлдвэрлэх мөн хагас кокс боловсруулах хосолмол ажиллагаатай болгох;
- Хагас коксжсон шахмал түлшний үйлдвэр барих.

Хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх цогцолбор байгуулах төсөл нь нийт 17,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан. 2011 онд 14,217.3 сая төгрөг, 2012 онд 2,348.8 сая төгрөг, нийт 16,566.1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

## 7. Эрсдэлийн үнэлгээ

"ДЦС-2"-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг "Дунд" гэж үзлээ.

## 8. Аудитын арга зүй

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан зарим ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

## 9. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;
- Нэгдсэн төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Барилгын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

- Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт;
- Эрчим хүчний тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нийслэлийн агаарын бохирдлыг буруулах тухай;
- Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоол шийдвэр, дүрэм, журам.

## 10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул хянаж, аудитын менежер З.Ариунзаяа удирдаж, аудитор Д.Дорждулам, шинжээч Б.Билэгт нар гүйцэтгэнэ.

## 11. Аудит хийх хугацаа

Аудитыг 2014 оны 3 дугаар сарын 1-нд эхэлж, 4 дүгээр сарын 30-нд дуусгаж, тайланг аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 5 дугаар сарын 7-нд УИХ-д хүргүүлнэ.

## 12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- Боловсон хүчин: ЯАГ- 47 өдөр\*2хүн- 94 хүн/өдөр
- Санхүүгийн нөөц: Цалингийн зардал: 119,070.0 мянган төгрөг
- Үйл ажиллагааны зардал: 285,768.0 мянга төгрөг
- Аудитын нийт зардал: 406,998.0 мянган төгрөг
- Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, скайнер, дектафон, болон бусад техник хэрэгсэл

### Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРГА



Б.БАТТУЯА

Боловсруулсан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА

Б.АЛТАНЗУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

З.АРИУНЗАЯА

АУДИТОР

Ц.ЭРДЭНЭЧУЛУУН

ШИНЖЭЭЧ

Б.БИЛЭГТ